

Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг

Ханбогд сум

Иргэдийн Хөгжлийн Төв

2017 оны 06-р сарын 28

Ханбогд сумын Гурван талт зөвлөл нь (ГТЗ)¹ малчдын гомдлыг шийдвэрлэх тохиролцоогоо баталгаажуулж, 2017 оны 5-р сарын 9-нд Малчдын гомдлыг барагдуулах хоёр гэрээнд гарын үсэг зурсан билээ. Энэ гэрээнд тохирсны дагуу Зөвлөл нь Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны үүргийг гүйцэтгэж ажиллахаар болсон. Хорооны журамд зааснаар уг Хороо нь Талуудын тохирсон шалгуурт нийцсэн малчин өрхийн нэхэмжлэлийг 2004, 2011 оны нөхөх олговрын хөтөлбөрт хамруулахаар хөөн хэлэлцэж шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулна.

Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны анхны хурлыг 2017 оны 6-р сарын 28-нд Иргэдийн хөгжлийн төвд зохион байгууллаа. Хорооны хуралд ГТЗ-ийн бүх гишүүд оролцоноос гадна Эрх Зүйн Нийцэл, Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газрын (ЭЗНХЗОГ)² чиглүүлэгч ажиглагчаар оролцсон болно.

Хорооны хурлаар Оюу Толгой компаниас 2004, 2011 онуудад хэрэгжүүлсэн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын хөтөлбөрийн нөлөөллийн бүс болон түүнд нөхөн олговрын багцыг тус тус хэлэлцлээ. Хэлэлцүүлгийн явцад нөлөөллийн бүс болон нөхөн олговрын багцын зарим хэсэгт тодруулах шаардлагатай зүйлс гарсан тул нөхөн олговор авахаар хөөн хэлэлцүүлэх хүсэлт гаргасан 83 малчин өрхийн нэхэмжлэлийг дараагийн хурлаар хэлэлцэхээр тохирсон болно. Хорооны дараагийн хурлыг 7-р сарын 25-нд товлов.

Талуудын байгуулсан Малчдын гомдол барагдуулах гэрээ болон Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны журмыг ОТ компаний хэвлэн гаргасан Орон нутгийн сонинны тусгай дугаараас үзэх боломжтой.

Нөхөн олговрын нэхэмжлэлийн хороо

¹ Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗНХЗОГ) чиглүүлж байна.

² Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗНХЗОГ) бол Дэлхийн Банкны Группын Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлагтай (ОТХОБА) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг хараат бус, бие даасан байгууллага болно.